

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2021 оны 04 сарын 16-ний өдрийн хурлын
12-р тогтоолын 7 дүгээр хавсралт



ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурлын журам (цаашид "Журам" гэх) нь Говь ХК (цаашид "Компани" гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид "ХЭХ" гэх)-ын эрх мэдэл, ХЭХ хуралдуулах тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх, хурлын зар мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хурал хуралдуулах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү журмыг Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Компанийн дүрэм болон зохицуулах байгууллагаас гаргасан бусад дүрэм журмын хүрээнд компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-өөс боловсруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашиглана.
- 1.3 Компанийн эрх барих дээд байгууллага нь ХЭХ болно.
- 1.4 ХЭХ нь Компанийн тухай хуулийн 62.1, Компанийн дүрмийн 6.1.9-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 1.5 ХЭХ-ын эрх мэдлийн хүрээний асуудлыг компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага төлөөлөн хэрэгжүүлэхгүй.

Хоёр. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛД САНАЛ ОРУУЛАХ

- 2.1 Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон ТУЗ, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор ТУЗ, эсхүл гүйцэтгэх удирдлагад бичгээр гаргаж болно.
- 2.2 Энэ журмын 2.1-д заасан санал нь хууль тогтоомжид заасан үндэслэл, мэдээлэл, шаардлагыг хангаж байгаа эсэх болон ХЭХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалт, нэр дэвшигчдийн бүртгэлд бүртгэх эсэхийг ТУЗ шийдвэрлэж, Компанийн тухай хуулийн 66-р зүйлд заасан журмын дагуу санал гаргагч хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.
- 2.3 ХЭХ-ын хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдээс санал ирээгүй, эсвэл компанийн удирдах байгууллагад нэр дэвшүүлж байгаа хүний тоо нийт сонгогдох хүний тоонд хүрэхгүй байгаа бол ТУЗ-ийн зүгээс хурлаар хэлэлцэх асуудал оруулах, мөн нэмж нэр дэвшүүлэх эрхтэй болно.

Гурав. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР ГАРГАХ

- 3.1 Компанийн ХЭХ нь ээлжит ба ээлжит бус байна.
- 3.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ТУЗ-ийн шийдвэрээр 4-р сарын 30-ны дотор, ээлжит бус хурлыг шаардлагатай үед тус тус зарлан хуралдуулна.
- 3.3 Дараах тохиолдолд ээлжит бус хурлыг ТУЗ-ийн шийдвэрээр зарлан хуралдуулна.

- 3.3.1 ТУЗ-ийн нийт гишүүдийн 50-иас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
- 3.3.2 ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;
- 3.3.3 Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;
- 3.3.4 Компанийн өр хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;
- 3.3.5 Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргасан;
- 3.3.6 Эрсдэл, аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;
- 3.3.7 Хууль тогтоомж, компанийн дүрэмд заасан бусад тохиолдол;
- 3.4. ТУЗ энэ журмын 3.3.2-д заасан санал, шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах, эсэх талаар шийдвэр гаргана.
- 3.5. ТУЗ энэ журмын 3.3.2-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах шийдвэр гаргасан тохиолдолд санал шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор тухайн хурлыг хуралдуулна.
- 3.6. ТУЗ энэ журмын 3.4-д заасан хугацаанд ХЭХ хуралдуулах тухай шийдвэр гаргаагүй тохиолдолд 3.3.2-д заасан санал, шаардлага гаргасан этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг бие даан гаргаж болно.
- 3.7. Хурал хуралдуулах шийдвэрийг ТУЗ, эсхүл хууль тогтоомж, компанийн дүрэм, энэ журамд заасан этгээд гаргана.
- 3.8. ХЭХ зарлан хуралдуулах тухай шийдвэр нь хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан журмын шаардлагыг хангасан байх бөгөөд уг шийдвэрт Компанийн тухай хуулийн 60.2, Компанийн дүрмийн 6.1.4-д заасан зүйлийг заавал тусгана.
- 3.9. ХЭХ зарлан хуралдуулах шийдвэр гаргасан өдрөөс 40-өөс доошгүй хоногийн дараа ээлжит болон ээлжит бус хурлыг хуралдуулна.
- 3.10. ХЭХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь энэ журмын 4.4-д заасны дагуу нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15-20 дахь өдөр байхаар тогтооно.
- 3.11. ХЭХ хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлаар хэлэлцэх асуудал, хурлын тов болон хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг өөрчлөхийг хориглоно.
- 3.12. Энэ журмын 3.7-д заасны дагуу ХЭХ хуралдуулах шийдвэр гаргасан этгээд хурлын тооллогын комиссыг томилох бөгөөд уг комиссын үүргийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхээр тогтоож болно.

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2011 оны 04 сарын 16-ний өдрийн хурлын
12-р тогтоолын 1 дүгээр хавсралт

- 3.13. ХЭХ-ын хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийг хурлын тооллогын комиссын гишүүнээр томилохыг хориглоно.
- 3.14. ХЭХ-ын тооллогын комисс Компанийн тухай хуулийн 67.3-д заасан үүргийг хүлээх бөгөөд тооллогын комиссын дарга нь тооллогын үр дүнгийн үнэн зөвийг хариуцна.

Дөрөв. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ, МЭДЭЭЛЭХ

- 4.1. ХЭХ-ын зарыг нийтэд хүргэхдээ Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Хувьцаат компанийн ХЭХ-ын зар хүргэх, хяналт тавих журам”-ыг дагаж мөрдөнө.
- 4.2. ХЭХ хуралдуулах шийдвэр гаргаснаас хойш 3 хоногийн дотор “ХЭХ-ын мэдэгдэл”-ийг холбогдох баримт бичгийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид тус тус хүргүүлнэ.
- 4.3. Энэ журмын 4.1-д заасан “ХЭХ-ын мэдэгдэл”-ийг хүргүүлснээс 2 хоногийн дараа ХЭХ-ын зарыг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигч нарт мэдээлнэ.
- 4.4. Энэ журмын 4.2-д заасан мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлнэ.
- 4.5. ХЭХ-ын зарыг нийтэд мэдээлсэн өдөр гэдгийг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэсэн өдрийг тооцно.
- 4.6. ХЭХ-ын зард Компанийн тухай хуулийн 65.4 болон энэ журмын 4.1-д заасан холбогдох журмын 3.7-д заасан мэдээллийг заавал тусгана.
- 4.7. ХЭХ-аар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг энэ журмын 4.5-д заасан өдрөөс хойш 5 хоногт багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Тав. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ

- 5.1. ХЭХ хуралдуулах шийдвэрийг хэрэгжүүлэх, хурлын зар мэдээлэл явуулах, хурлын баримт бичгийг бэлтгэх, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах зэрэг хурлын бэлтгэлийг бүрэн хангаж товлосон өдөр, цагт хурлыг хуралдуулах ажлыг зохион явуулах үүргийг ТУЗ-өөс томилсон комисс гүйцэтгэнэ.
- 5.2. ХЭХ-ыг ТУЗ-өөс томилсон дарга даргалж, урьдчилан бэлтгэсэн дараалал, дэгийн дагуу удирдаж явуулна.
- 5.3. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээдээс гаргасан бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч хуралд оролцох эрхтэй бөгөөд хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр болон Иргэний хуульд заасан бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно.

- 5.4. ХЭХ-д хувьцаа эзэмшигчийг төлөөлж оролцох этгээд нь энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэх бөгөөд, итгэмжлэл нь гагцхүү тухайн хуралд хүчинтэй байна. ХЭХ хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл нь дараагийн хуралд хүчинтэй хэвээр байна.
- 5.5. ХЭХ-аас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг ХЭХ-д оролцсон гэж үзнэ. Харин ээлжит бус хуралд хувьцаа эзэмшигчид заавал өөрийн биеэр болон бичгээр үйлдсэн итгэмжлэлээр оролцоно.
- 5.6. Компанийн нийт гаргасан саналын эрх бүхий хувьцааны 51-ээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурлын ирцийг хүчин төгөлдөр болсон гэж үзнэ.
- 5.7. ХЭХ-ын ирц энэ журмын 5.6-д заасан хэмжээнд хүрээгүй тохиолдолд энэ тухай тэмдэглэл үйлдэж, хойшлогдсон хурлын товыг тогтоож, хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гаргаж, хурлыг хойшлуулсан тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид холбогдох баримт бичгийн хамт ажлын 4 хоногт хүргүүлнэ.
- 5.8. Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдах өдрөөс ажлын 7-оос доошгүй хоногийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг энэ журмын 4.3-д заасан хэлбэр, шаардлагын дагуу дахин мэдээлнэ.
- 5.9. Хойшлогдсон хуралд бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй бөгөөд энэ журмын 5.7-д заасны дагуу хойшлогдсон ХЭХ-д бичгээр ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд оруулан тооцно.
- 5.10. Хойшлогдсон ХЭХ нь энэ журмын 5.8-д заасан хугацаанд хуралдаж чадаагүй бол шинээр хурал зарлах бөгөөд ирцийг энэ журмын 5.6-д зааснаар тогтооно.
- 5.11. ХЭХ нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэж болохгүй бөгөөд хэрэв хэлэлцсэн бол тухайн асуудлаар гаргасан шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

Зургаа. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААС ШИЙДВЭР ГАРГАХ

- 6.1. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол компанийн гаргасан нэг ширхэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байх бөгөөд саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нь санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр санал өгөх эрхтэй.
- 6.2. ХЭХ-аар шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд хувьцаа эзэмшигч өөрийн өгөх саналаа саналын хуудсанд тэмдэглэн тогтоосон журмын дагуу ХЭХ-ын тооллогын комисст ирүүлнэ.
- 6.3. Энэ журмын 6.2-д заасан саналын хуудасны агуулга, загварыг ХЭХ-ыг зарласан этгээд батлах бөгөөд саналын хуудсанд Компанийн тухай хуулийн 71.4-д заасан зүйлсийг тусгана.
- 6.4. Саналын хуудсыг Компанийн тухай хуулийн 72-р зүйлд заасан нөхцөлийг хангасан тохиолдолд хүчинтэйд тооцно.

- 6.5. ХЭХ-аар хэлэлцэж байгаа асуудлаар гарах шийдвэрийг тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Компанийн тухай хуулийн 63.5 болон 63.7, Компанийн дүрмийн 6.1.16-д заасны дагуу саналын эрхийн ердийн ба дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 6.6. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ.
- 6.7. ХЭХ-ын тэмдэглэлийг Компанийн тухай хуулийн 74-р зүйлд заасны дагуу хөтөлж, тэмдэглэлд тэмдэглэл хөтлөгч, хурлын дарга нар гарын үсэг зуран баталгаажуулж хадгална.
- 6.8. ХЭХ зохион байгуулах комисс ХЭХ зохион байгуулалтыг дүгнэсэн тайланг гаргаж ТУЗ-д танилцуулна.
- 6.9. ХЭХ-ын материалыг хурал хуралдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлнэ.
- 6.10. ХЭХ болон түүний шийдвэрийн талаар хуралд оролцоогүй, эсхүл оролцсон боловч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч Компанийн тухай хуулийн 70.1-д заасан үндэслэлээр шүүхэд болон Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргаж болно.

Долоо. ХУРЛЫГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХ

- 7.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг дараах тохиолдолд цахим хэлбэрээр зохион байгуулж болно:
 - 7.1.1. ТУЗ-ийн хоёр болон түүнээс дээш тооны хараат бус гишүүн, эсхүл компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны 10 болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээд санал, шаардлага гаргасан;
 - 7.1.2. ТУЗ шийдвэр гаргасан;
- 7.2. Энэхүү журмын 7.1-д заасан хурлыг дараах хэлбэрээр зохион байгуулж болно:
 - 7.2.1 Зайнаас /мэдээлэл технологи, программ хангамж ашиглан хурлын бүх үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах/;
 - 7.2.2 Хосолсон /танхим болон зайнаас/;
- 7.3 Компани өөрийн боловсруулсан, эсхүл гэрээний үндсэн дээр бусад этгээдийн мэдээллийн технологи, программ хангамжийг ашиглан хурлыг зохион байгуулж болно.
- 7.4 Энэ журмын 7.3-д заасан цахим хурлыг зохион байгуулах мэдээллийн технологи, программ хангамжийн талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг хурал хуралдуулах шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор Хороонд хүргүүлнэ.
- 7.5 Цахим хурал зохион байгуулах мэдээллийн технологи, программ хангамж дараах нөхцөл шаардлагыг хангасан байна:
 - 7.5.1. Хувьцаа эзэмшигчдэд дараах боломжийг олгосон байх:
 - 7.5.1.1 Цахимаар болон биеэр бүртгүүлэх;

- 7.5.1.2 Санал болон асуултыг цахимаар болон цаасан хэлбэрээр урьдчилан хүргүүлэх;
 - 7.5.1.3 Хурлын үйл ажиллагааг онлайн хэлбэрээр шууд үзэх;
 - 7.5.1.4 Хурлын үеэр цахимаар санал өгөх, асуулт тавих, хэлэлцүүлэгт оролцох;
 - 7.5.1.5 Саналын хуудас хүчингүй болох эрсдэлийг хаах /саналын хуудас бүрэн гүйцэд, зөв бөглөгдсөн эсэхэд анхааруулга өгөх/;
 - 7.5.1.6 Мэдээллийн нууцлал, ашиглалт, хадгалалт хамгаалалтын аюулгүй байдлыг хангасан байх;
- 7.6 Хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах тохиолдолд дараах үүргийг хүлээнэ:
- 7.6.1. Хуралд оролцохоор бүртгүүлэх хүсэлт гаргагчийн биеийн байцаалт, итгэмжлэлээр оролцох этгээдийн итгэмжлэлийг хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалттай тулган баталгаажуулах;
 - 7.6.2. Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан нэвтрэх эрх, нууц үгийг хуралд оролцохоор бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдэд биечлэн олгох, цахим шуудан эсхүл гар утасны дугаараар дамжуулан илгээх;
 - 7.6.3. Хуралд ашиглах программ хангамжийг ашиглах заавар, зөвлөгөө бүхий мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх;
 - 7.6.4. Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдэд шуурхай зөвлөгөө, туслалцаа үзүүлэх мэдээлэл харилцааны цахим суваг болон шуурхай утасны дугаар ажиллуулах;
 - 7.6.5. Хурлын материалыг цахим хурал дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор Хорооны мэдээллийн санд хүргүүлэх;
 - 7.6.6. Хурлын материал, хурлын үйл явцын бүтэн дүрс бичлэг, санал хураалтын баримт зэргийг засварлах, өөрчлөх боломжгүй хэлбэрт шилжүүлэн компанийн цахим архивын баримт болгох;
- 7.7 Хурлыг хуралдуулах боломжгүй техникийн нөхцөл үүссэн тохиолдолд хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг ТУЗ товлонэ.

Найм. БУСАД

- 8.1 Компани ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарах асуудлыг Компанийн тухай хуулийн 73-р зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно.
- 8.2 Эчнээ санал хураалт явуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 8.3 Энэ журамд тусгагдаагүй аливаа асуудлыг Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, төрийн зохицуулах байгууллага, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гаргасан дүрэм, журамд зааснаар шийдвэрлэнэ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ